



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

**СУМДЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ
АШИГЛАЛТАД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН
ТАЙЛАН**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2025.04.01

1. ТАНИЛЦУУЛГА

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сард өгсөн чиглэлийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээ, 2014-2021 онд хэрэгжсэн “Сумын төвийн шинэчлэл”, “Шинэ сум төсөл” зэрэг төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ. Сумуудын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ нэвтэрсэн мэдээллийг яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газарт, харьяа “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас авч авч нэгтгэсэн.

Нэгтгэлийн хүрээнд “Дотоод томилолтоор ажиллах тухай” Хот байгуулалт, Барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/45 дугаар тушаал батлуулан, тушаалын 1-р хавсралтаар батлагдсан удирдамжид заасан 6 сумдын инженерийн шугам сүлжээний ашиглалтад хяналт, шинжилгээ хийсэн тайланг танилцуулж байна.

2. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Сумдын инженерийн шугам сүлжээний ашиглалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

3. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, ХЯЗГААРЛАЛТ, АРГА, АРГАЧЛАЛ

Хяналт, шинжилгээний хамрах хүрээ: Хот байгуулалт, Барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Дотоод томилолтоор ажиллах тухай” 2025 оны Б/45-р тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан удирдамжид заагдсан 4 аймгийн 6 суманд 2025 оны 03-р сарын 25-27-ны өдрүүдэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилолтоор ажиллалаа. Үүнд:

Дарга	Х.Ган-Очир	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Гишүүд	А.Гэрэлт-Од	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч
	Ц.Ууганбаяр	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч

Инженерийн шугам сүлжээний ашиглалтад хяналт тавих сумууд:

- Төв аймгийн Эрдэнэ сум
- Төв аймгийн Борнуур сум
- Хэнтий аймгийн Эрдэнэмандал сум
- Сэлэнгэ аймгийн Баянгол сум
- Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум
- Дархан-Уул аймгийн Хонгор сум

Хяналт, шинжилгээний хамрах хүрээний хязгаарлалт:

Монгол Улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд нийслэл, 9 дүүрэг, 21 аймаг, 330 сумтай, нийслэл Улаанбаатар хотод хүн амын 50 орчим хувь нь ажиллаж, амьдарч байна.

Аймгийн төвүүдээс бусад 309 сумын төвийг суурин хүн амын тооноос нь хамааруулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1


№	Суурин хүн амын тоо	Сумын тоо	Нийт сумдад эзлэх хувь
1.	1000 хүртэл	200	64
2.	1001-2000 хүртэл	78	25
3.	2001-ээс дээш	31	11

Дээрх 309 сумын төвөөс инженерийн дэд бүтцийн хангамжтай 70, үлдсэн 239 сумын төв нь инженерийн дэд бүтцийн хангамжгүй байна.

Сумдад 2020 оны байдлаар нийтдээ 1085,1 мянган хүн ам амьдарч байгаа бөгөөд иж бүрэн инженерийн шугам сүлжээнд 70 сум холбогдсноос төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцад амьдардаг 11267 өрхтэй байна. Мэдээллийн эх сурвалж <https://www.1212.mn/>

Мөн 2014-2020 онуудад “Сумын төвийн шинэчлэл” төслийг 16 аймгийн 16 суманд хэрэгжүүлсэн байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдад хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл ирүүлэх тухай 4, 5 дугаартай дотоод албан бичгийг Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газарт, 2023 оны 01 сарын 20-ны өдрийн 03/198 тоот албан албан бичгийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т тус тус хүргүүлж мэдээллийг авч нэгтгэлээ.



Дээрх газруудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн үзэхэд аймгийн төвүүдээс бусад 309 сумаас инженерийн дэд бүтцэд холбогдсон (1952 оноос хойш) нийт 117 сумын судалгааг гаргалаа /Хавсралт 1/. Үүнээс:

- 1952-2000 оны хооронд холбогдсон – 7 сум
- 2000 оноос хойш хэрэгжсэн- 110 сум

2000-2024 онд хэрэгжсэн 110 сумдын инженерийн дэд бүтцийн арга хэмжээний 2020 оноос хойших төсөл арга хэмжээнүүд нь “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөр, “Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл”, “Гадна инженерийн шугам сүлжээ”, Сумын төвийн цэвэр усны шугам, “Төвийн болон гэр

хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт” зэрэг нэршлээр 43 сумдад хэрэгжиж байна.

Мөн 2020 оноос хойш хэрэгжиж буй инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээ нь аймгийн төвийн суманд 43, бусад суманд 43, 2 дүүрэг, нийт 88 төсөл арга, хэмжээ хэрэгжиж байгаагаас 24 арга хэмжээний ажил дуусаж, 64 арга хэмжээний ажил үргэлжилж байна /Хавсралт 2/.

Нэгтгэсэн 117 сумын инженерийн дэд бүтцийн мэдээлэл дутуу, ашиглалтад орсноос хойш ашиглагдаж байгаа болон ашиглагдахгүй байгаа нь тодорхойгүй, инженерийн шугам, сүлжээнд холбогдсон сумдын тоо дутуу байгаа тул Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газар холбогдох байгууллага болон <https://urban.gov.mn/> системийн мэдээллүүдтэй тулган, дэлгэрэнгүй мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэх, шинэчлэх зайлшгүй шаардлага байна.

5. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1. Сумуудын ерөнхий мэдээлэл, инженерийн байгууламжийн ашиглалт, үр дүн:

Төв аймгийн Эрдэнэ сум

Төв аймгийн Эрдэнэ сум нь хэвтээ чиглэлийн улсын зэрэглэлтэй авто зам дагуу байрласан. Улаанбаатар хотоос 77 км, аймгийн төвөөсөө 97 км зайд байрладаг.

Ажлын хэсэг 2025 оны 03-р сарын 25-ны өдөр ажилласан. Уулзалтад тус сумаас ИНХ-ийн дарга н.Мөнхбат, Засаг дарга н.Мөнгөнбаяр, Засаг даргын орлогч н.Ариунболд, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, “Эрдэнэ тохижилт” ОНӨААТҮГ-ийн захирал н.Баасандэмбэрэл, Хит повер ресурс ХХК захирал н.Авирмэд нар оролцлоо.



Хүн ам- 3800

Өрхийн тоо- 1500 /сумын төв 450 өрх/

Төрийн албан хаагч- 227

Тус сумын төвийн хэсгийн төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчдын 4 айлын орон сууц, 3 давхар 9 айлын орон сууц, хувийн байгууллага, нийт 16 объект дулаан, бохирт холбогдсон. Мөн 100 айлын орон сууцны ажил хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж эхэлсэн бөгөөд 25 айлын орон сууц ашиглалтад орсон бөгөөд дулаанд холбогдсон.

Шугам сүлжээнд холбогдсон байгууллага, айл, өрхийн хувьд ашиглалт хэвийн явагдаж байна.

Дулааны ашиглагч байгууллагаар Хит повер ресурс ХХК ажиллаж байгаа бөгөөд 2019 онд уурын зуухыг шинэчлэн ашиглалтад оруулсан, хэвийн ажиллаж байна.

Гэр хорооллын дундуур инженерийн шугам сүлжээ байхгүй.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны захиалгаар 2022-2024 онд Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт төсөл арга хэмжээний нэгдүгээр үе шатны 4,5 тэрбумын ажил хэрэгжиж, гүйцэтгэгчээр "Билгүүн од констракшн ХХК" шалгаран ажиллаж, 2024.12.30-ны өдрийн ББКД-122/2024 актаар хүлээн авсан. Тус төсөл арга хэмжээний ажлын хүрээнд 3,3 км цахилгаан, дулааны 366м шугам, 150 м-ийн 2 гүний худаг, 1300м шугам, 50м³-ын усан сан, цэвэр усны 3922м шугам, 50м³-ийн цэвэрлэх байгууламж /эхний ээлжийн 25м³ нь ашиглалтад орсон/, бохир усны 6100м шугам зэрэг магистраль шугамууд хийгдсэн. Цэвэр усны шугам усан сангаас уурын зууханд холбогдсон.

Энэ ажил нь тухайн сумын инженерийн шугам сүлжээнд холбогдох эхний шатны ажил бөгөөд дараагийн шатны "Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Төв, Эрдэнэ сум/" төсөл арга хэмжээ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд тендер зарлахаар бэлтгэл ажил хийгдэж, Хот Байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарын бичгийн даргын 2025 оны 03-р сарын 21-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд гэр хорооллын инженерийн шугам сүлжээг түлхүү хийж гүйцэтгэнэ.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 450.0 сая төгрөгийг гэр хорооллын инженерийн шугамын ажилд баталсан бөгөөд улсын хөрөнгөөр хийгдэх инженерийн дэд бүтцийн ажлын хүрээнд гудамжаар хийгдэх төв шугамаас айл өрхүүд рүү холбох шугамын ажилд зарцуулахаар төлөвлөж байна. Тухайн ажлын хүрээнд айл өрхүүд рүү татах шугамын тодорхой хувийг /50%/ ОНХС-ын батлагдсан дээрх хөрөнгөөс дэмжлэг үзүүлэх хүрээнд хуваарилахаар төлөвлөж байна. Сумын төвд 450 орчим өрхтэй, үүнээс ойролцоогоор 280 өрх эхний ээлжид холболт хийх төлөвлөлттэй, иргэд хүлээлттэй байна.

Сум нь тохижилт, хог хаягдал, ногоон байгууламж хариуцсан "Эрдэнэ тохижилт" ОНӨААТҮГ байгуулан ажиллуулдаг. Тус байгууллагаар инженерийн шугам сүлжээний байгууламжаа хариуцуулан ажиллана.



Гэр хорооллын одоогийн байдал



Уурын зуух /2019 онд шинэчлэгдсэн/



Усан сан /50м³/

Цэвэрлэх байгууламж /25м³/

2022-2024 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжсэн “Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт” төсөл арга хэмжээг “Билгүүн од констракшн” ХХК гүйцэтгэж, хугацаандаа ашиглалтад орсон. /2024.12.30, ББКД-122/2024/. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл сайн гэж орон нутгийн зүгээс үнэлсэн.

2. “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Төв, Эрдэнэ сум/” төсөл арга хэмжээний тендер 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас зарлагдсан байна.

3. Орон нутгаас гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байгаатай холбогдуулан сумын тохижилт, хог хаягдал, ногоон байгууламж хариуцсан “Эрдэнэ тохижилт” ОНӨААТҮГ-аараа ашиглалтыг хариуцуулахаар шийдвэрлэсэн.

4. Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж байгаатай холбогдуулан орон нутгаас иргэдээ дэмжиж хагас тэрбум төгрөгийг орон нутгийн сангийн хөрөнгөөс хуваарилан батлуулж ажиллаж байна.

5. Орон нутгаас төсөвт суулгасан хөрөнгөөр шугам сүлжээнд холбогдох айл өрхүүдийн зардлын 50%-ийг дэмжлэг болгон өгч, эргээд сар бүрийн төлбөр дээр төлбөрийг нэмэгдүүлж тооцон дуусгах, эргэж хуримтлагдсан хөрөнгөөр дараагийн

шатны айл өрхүүдийг холбох замаар тооцон төлөвлөж байгаа нь орон нутгаас хөрөнгө оруулалтыг дэмжсэн, ажлыг үр дүнтэй болгох нэг арга хэрэгсэл болж байна.


6. Дэд бүтцийн ажил хийгдсэнээр гэр хорооллын 280 айл өрх нэгдсэн шугамд холбогдох бөгөөд энэ нь сумын төвийн гэр хорооллын нийт өрхийн 60 орчим хувь нь хамрагдах юм.

7. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д тухайн сумын мэдээллийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй.

Төв аймгийн Борнуур сум

Төв аймгийн Борнуур сум нь босоо чиглэлийн улсын зэрэглэлтэй авто зам дагуу байрласан. Улаанбаатар хотоос 105 км, аймгийн төвөөсөө 155 км зайд байрладаг.

Ажлын хэсэг 2025 оны 03-р сарын 26-ны өдөр ажилласан. Уулзалтад тус сумаас Засаг дарга н.Батболд, “Нарт хөгжлийн сүлжээ” ХХК-ний захирал н.Гомбодорж нар оролцсон.



Хүн ам- 4986

Өрхийн тоо- 3500 /сумын төв 460 өрх/

Төрийн албан хаагч- 240

Тус сумын төвийн хэсгийн төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчдын 8 айлын 4 орон сууц, 24, 36 айлын орон сууц хувийн байгууллага, нийт 18 объект дулаанд, 6 байгууллагын 13 объект бохирт холбогдсон.

Шугам сүлжээнд холбогдсон байгууллага, орон сууцны хувьд ашиглалт хэвийн явагдаж байна.

Дулааны ашиглагч байгууллагаар Ану сервис ХХК ажиллаж байна.

Гэр хорооллын дундуур инженерийн шугам сүлжээ байхгүй.

2022-2024 онд Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт төсөл арга хэмжээний нэгдүгээр үе шатны 3,8 тэрбумын ажил хэрэгжиж, гүйцэтгэгчээр "Сайн констракшн ХХК" шалгаран ажиллаж, 2024.11.27, ББКД-98/2024 актаар хүлээн авсан. Тус төсөл арга хэмжээний ажлын хүрээнд дулаан, цэвэр усны шугам, 50м³-ийн цэвэрлэх байгууламж /25м³ нь ашиглалтад орсон/ зэрэг магистраль шугамууд хийгдсэн. Цэвэрлэх байгууламжийн ашиглалт маш муу, бохирын ариутгал хангалттай цэвэрлэхгүй байна. Зун үерийн усны лаг цэвэрлэх байгууламжийг дүүргэсэн.

Энэ ажил нь тухайн сумын инженерийн шугам сүлжээнд холбогдох эхний шатны ажил бөгөөд дараагийн шатны “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Төв, Борнуур сум/” төсөл арга хэмжээ Хот

байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд тендер зарлахаар бэлтгэл ажил хийгдэж, Хот Байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарын бичгийн даргын 2025 оны 03-р сарын 21-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд гэр хорооллын инженерийн шугам сүлжээг түлхүү хийж гүйцэтгэнэ.

Сумын төвд 460 орчим өрхтэй, бүх өрхийг холболт хийх төлөвлөлттэй, урьдчилсан байдлаар шугамаас айл өрхүүдийг холбоход 100- 500 м зайд ойролцоогоор 8.0- 15.0 сая төгрөг, айлын дотоод холболт 1.0-2.0 сая төгрөг, нийт 10.0- 17.0 сая төгрөгийн зардал гарах тооцоог “Ану сервис” ХХК-тай хамтран гаргаж үзсэн.

Сум нь цэвэрлэх байгууламж, шугам сүлжээгээ “Нарт хөгжлийн сүлжээ” ХХК-тай нэг жилийн гэрээ байгуулан, орон нутгаас ашиглалтын зардалд 60,0 сая төгрөгийн батлуулан, санхүүжүүлж ажиллаж байна. Тухайн компани нь шинээр байгуулагдсан тухайн нутагт шилжин суурьшиж байгаа иргэн байгуулсан. Одоогоор 3 хүний орон тоотойгоор ажиллаж байгаа. Тухайн компани нь холбогдох тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлтээ өгсөн.

Цэвэрлэх байгууламжийн ашиглалт маш муу, тунгаагуурын температур 14°C-т хүрэхгүй байгаа тул бохирын ариутгал хангалттай цэвэрлэхгүй байна. Зун үерийн усны лаг цэвэрлэх байгууламжийг дүүргэснийг цэвэрлэсэн. Иймд 2-р шатны ажлын хүрээнд лагийн байгууламжийг битүүлэх, бохир соруулах 1 машин авч өгөх саналтай байна.

Орон нутгийн зүгээс инженерийн шугам сүлжээний байгууламжаа “Нарт хөгжлийн сүлжээ” ХХК-нд хариуцуулан ажиллахаар төлөвлөж байна.

Цэвэрлэх байгууламж
/Бохироос үнэр ихээр гарч байсан/

Цэвэрлэх байгууламжийн байршил
/сумийн айл өрхийн дээд талд/



Шинэ
цэвэрлэх
байгууламж
/50м³/



2022-2024 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил

Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжсэн “Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт” төсөл арга хэмжээг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж, хугацаандаа ашиглалтад орсон. /2024.11.27, ББКД-98/2024/. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл сайн гэж Орон нутгийн зүгээс үнэлсэн.

2. Эхний ээлжийн төсөл арга хэмжээгээр хэрэгжсэн цэвэрлэх байгууламж нь сумынхаа дээд талд хуучин цэвэрлэх байгууламжийнхаа хажууд байрлуулсан нь байршлын хувьд сонголт буруу хийгдсэн гэж дүгнэж байна. Газар дээр нь очиж үзэхэд хуримтлагдсан бохироос үнэр ихээр гарч байсан.

3. Цэвэрлэх байгууламжийн ашиглалт маш муу, тунгаагуурын температур 14°C-т хүрэхгүй байгаа тул бохирын ариутгал хангалттай цэвэрлэхгүй байгаа. Зун үерийн усны лаг цэвэрлэх байгууламжийг дүүргэснийг цэвэрлэсэн. Иймд 2-р шатны ажлын хүрээнд лагийн байгууламжийг битүүлэх, бохир соруулах 1 машин авч өгөх саналыг “Нарт хөгжлийн сүлжээ” ХХК-аас орон нутгийн удирдлагадаа тавьсан байна.

4. “Сумын төвийн инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил /Төв, Борнуур сум/” төсөл арга хэмжээний тендер 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас зарлагдсан байна.


5. Орон нутгаас иргэдийнхээ оролцоог дэмжих хүрээнд цэвэрлэх байгууламж, бохирын шугам сүлжээг “Нарт хөгжлийн сүлжээ” ХХК-д жилийн гэрээ байгуулан ашиглалтын зардалд 60.0 сая төгрөгийг батлан ажиллаж байгаа бөгөөд гэр хорооллын инженерийн шугам сүлжээ ашиглалтад ороход ашиглалтыг хариуцуулахаар ажиллаж байна.

6. Дулаан шугам сүлжээ хариуцаж байгаа “Ану сервис” ХХК-тай хамтран айл өрхтэй зөвшилцөн дулаанд холбоод эргээд сар бүрийн төлбөр дээр төлбөрийг нэмэгдүүлж тооцон боломжит хугацаанд /2-3 жил/ төлбөрийг барагдуулах замаар холболтыг хийхээр төлөвлөж эхний ээлжид 50-60 өрхтэй санал солилцсон байна.

7. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д тухайн сумын мэдээллийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй.

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум нь хэвтээ чиглэлийн орон нутгийн зэрэглэлийн авто зам дагуу байрласан. Улаанбаатар хотоос 200 км, аймгийн төвөөсөө 145 км зайд байрладаг.



Ажлын хэсэг 2025 оны 03-р сарын 25-ны өдөр ажилласан. Уулзалтад тус сумаас Засаг дарга н.Мөнх-Оргил оролцсон.

Хүн ам- 2080

Өрхийн тоо- 800 /сумын төв 200 өрх/

Төрийн албан хаагч- 240

Тус сумын төвийн хэсгийн төрийн байгууллага 3 болон хувийн 3 байгууллага нийт 6 байгууллага дулаанд холбогдсон.

Шугам сүлжээнд холбогдсон байгууллагын хувьд ашиглалт хэвийн явагдаж байна.

Дулааны ашиглагч байгууллагаар Өндөрхаан илч ХХК ажиллаж байна.

Гэр хорооллын дундуур инженерийн шугам сүлжээ байхгүй. Дулаан, бохирт холбогдсон байгууллага, айл өрх байхгүй.

Суманд хэрэгжсэн инженерийн шугам сүлжээний ажлын хөрөнгө оруулалтын талаар орон нутгийн хувьд тодорхой мэдээлэлгүй Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 2022-2024 онд хийж 2024 оны сүүлээр улсын комисс ажилласан гэсэн боловч яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Ж.Орхонбаяраас тодруулахад яамны захиалгаар ийм ажил хийгдээгүй бөгөөд тус хөрөнгө оруулалтын талаар дараах мэдээллийг өгсөн.

Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон/-ний нийт 11,1 тэрбум төгрөгийн ажлыг Монгол Улсын Засгийн газрын “Жагсаалт батлах тухай” 359-р тогтоолын 2 дахь заалтын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /хуучнаар БХБС/-ын 2021 оны 12-р сарын 10-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 267-р тушаалаар Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газарт эрх шилжүүлэн хэрэгжсэн байна.

Тус ажлыг аймгийн зүгээс 5 багц болгон зарлаж, 2-р багц буюу “Сумын төвийн усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж /Хэнтий, Баян-Адрага сум/ • Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Хэнтий, Норовлин сум/ • Цэвэрлэх байгууламж /Хэнтий, Цэнхэрмандал сум /”-ын ажлыг 5.6 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр “Хангайн илч дулаан” ХХК шалгарч, 2024 оны 12-р сард комисс ажилласан байна.Туслан гүйцэтгэгчээр “Өндөрхаан илч” ХХК ажилласан.

Тус ажлын хүрээнд шугам сүлжээнд сумаас ямар ч хэрэглэгч холбогдоогүй, хэрэглээ байхгүйн улмаас шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж туршилт тохируулга хийх боломжгүй байна.

Дээрх хөрөнгө оруулалтын ажлууд комисс ажилласан боловч ашиглалт байхгүй, айл өрх, ААНБ холбогдоогүй, сумын төвийн төв дундуур шулуун нэг гудамжинд л тавигдсан.


Мөн 2019 онд халаалтын шугамыг хувийн хөрөнгөөр Өндөрхаан илч ХХК хийсэн ч одоогоор холболт хийгдээгүй хуучин шугамаа ашиглаж байна.

Энэ онд аймгийн хөрөнгөөр төрийн байгууллагуудаа бохиртой холбох ажлыг хийж гүйцэтгэхээр тодорхой хэмжээний /150.0 сая орчим/ хөрөнгө баталсан мэдээллийг сумын Засаг даргаас өгсөн.

Сумын төвд 280 орчим өрхтэй, Сумын төвийн төвд байрлах байшин хорооллын /тухайн байшин хороолол нь хуучин уурхайн ашиглалтын хүрээнд баригдсан нэг давхар байшингууд/ 80 орчим айл өрхийг дулааны шугамд холбох тооцоо судалгааг 2020 онд урьдчилсан байдлаар 30- 200м зайд ойролцоогоор 8.0-14.0 сая төгрөгийн зардал гарах тооцоог гаргаж үзсэн, цаасан дээр буусан тооцоо судалгаа байхгүй.

Орон нутгийн зүгээс инженерийн шугам сүлжээний ашиглалтыг яаж авч явах тодорхой санал, санаачилгагүй, ашиглалтыг хариуцуулах ямар нэгэн улсын болон хувийн байгууллага байхгүй байна.

Орон нутгийн удирдлагын зүгээс энэ жил манай сумын 100 жилийн ой тохиож байгаа инженерийн шугам сүлжээний ажлаасаа илүү он дамжин хэрэгжиж байгаа Соёлын төвийн барилгын ажлыг дуусгах нэн тэргүүний ажил гэж үзэж байна.



Шугам сүлжээ хийгдсэн төв гудамж



Усан сан



Дулааны шугам

Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтаар 2022-2024 онд хэрэгжсэн төвийн хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ төсөл арга хэмжээг гүйцэтгэн 2024 онд

комисс ажилласан гэсэн боловч үндсэн гүйцэтгэгчийн мэдээлэл сайн мэдэхгүй байсан нь орон нутгийн зүгээс нутаг дэсвэртээ хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудад ач холбогдол өгөхгүй байгаа харагдаж байна.

2. Хийгдсэн инженерийн шугам сүлжээний ажил үр дүнгүй эзэнгүйдэх байдалтай байна.

3. Тухайн орон нутагт улсын хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээнүүд /БХБОСЯ-ны захиалгатай далан сувгийн ажил, ССАЖЗЯ-ны захиалгатай Соёлын төвийн барилга/ гэрээний хугацаа дууссан ашиглалтад ороогүй, удаашралтай, гүйцэтгэгч байгууллагууд ажлаа хийхгүй орхиод явсан, ажил зогссон, холбогдох байгууллагуудад албан тоот хүргүүлсэн байдалтай байна.

4. Орон нутгаас инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хэнд хариуцуулах, цаашид яаж авч явах төлөвлөлт, төлөвлөгөө байхгүй байна.


5. Орон нутгийн удирдлагын зүгээс энэ жил манай сумын 100 жилийн ой тохиож байгаа тул Соёлын төвийн барилгын ажлыг дуусгах тал дээр түлхүү анхаарч байна.

6. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д тухайн сумын мэдээллийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй.

Сэлэнгэ аймгийн Баянгол сум

Сэлэнгэ аймгийн Баянгол /Баруунхараа/ сум нь босоо чиглэлийн улсын зэрэглэлтэй авто зам дагуу байрласан. Улаанбаатар хотоос 154 км, аймгийн төвөөсөө 170 км зайд байрладаг.

Ажлын хэсэг 2025 оны 03-р сарын 26-ны өдөр ажилласан. Уулзалтад тус сумаас ИНХ-ийн дарга, Засаг дарга, “Ануужээ” ХХК-ийн захирал н.Энхтүвшин нар оролцлоо.



Хүн ам- 5641

Өрхийн тоо- 1682 /сумын төв 1100 өрх/

Төрийн албан хаагч- 241

Тус сумын төвийн хэсгийн төрийн болон төрийн бус 26 аж ахуйн нэгж, байгууллага, төвийн орон сууц, гэр хорооллын 126 өрх, дулаан, бохир, цэвэр усны шугамд холбогдсон.

Шугам сүлжээнд холбогдсон байгууллага, айл, өрхийн хувьд ашиглалт хэвийн явагдаж байна.

Дулааны ашиглагч байгууллагаар Анужин ХХК ажиллаж байгаа бөгөөд 2012 оноос цэвэр, бохир усны шугам сүлжээг давхар хариуцан ажиллаж байгаа.

Гэр хорооллын дундуур инженерийн шугам сүлжээ байхгүй.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны захиалгаар 2024-2026 онд Цэвэрлэх байгууламжийн барилга төсөл арга хэмжээ гүйцэтгэгчээр "Алтайн

үндэс констракшн" ХХК шалгаран 2024.11.25- 2026.08.10-ны өдрийг хүртэл гэрээ байгуулсан, 2025 оны хавраас ажлыг эхлүүлнэ.

Тус сумын инженерийн шугам сүлжээ анх 1968 онд хийгдсэн, түүнээс хойш төрийн ганц нэг байр шинээр барихад болон цөөн тооны айл өрхүүд өөрсдийн хөрөнгөөр хийсэн 300 орчим метр шугам нэмэгдсэн.

Босоо тэнхлэгийн авто зам 2020-2024 онд хэрэгжих хугацаанд Анужин ХХК-ны зүгээс орон нутагтайгаа хамтран авто замын доогуур цэвэр, дулааны шугамын гаргалгааг гарган замын урд талын ААНБ, айл өрхийг холбох боломжит нөхцөлийг хангасан.

Замын урд талд гарсан шугамаас замын урд байрлах ААНБ, айл өрхүүдийг холбоход 124- 520м-ийн зайтай тул байгууллагуудаас дулаан, цэвэр усны шугамд холбуулах саналууд ирж байгаа тул, хавраас зарим нэг байгууллагуудыг өөрсдийнхөн хөрөнгөөр холбох ажлыг эхлүүлнэ.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд гэр хорооллын шугам сүлжээний зураг төсөв хийлгэхээр 100.0 сая төгрөг батлагдаж, ажлын даалгавар гарган хүргүүлсэн.

Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд Цэвэрлэх байгууламжийн барилга төсөл арга хэмжээ хэрэгжихээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулагдсан байна.

2. 1968 онд хийгдсэн 3000 орчим метр шугам сүлжээ өнөөдрийг хүртэл ашиглагддаг, дорвитой шинэчлэлт хийгдээгүй, шинээр баригдсан ААНБ болон айл өрхүүдийн өөрийн хөрөнгөөр хийгдсэн 300м шугам нэмэгдсэн байна.

3. Сумын дулаан, бохир, цэвэр усны ашиглалт, үйлчилгээг Анужин ХХК хариуцдаг. Тухайн байгууллага нь босоо тэнхлэгийн авто зам доогуур цэвэр ус, дулааныхаа шугамын гаргалгааг сүвэгчлэн гаргаж авсан давуу талтай байна.


4. 2025 онд аймгийн төсвийн хөрөнгөөр гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг, төсвийг хийлгэхээр батлуулан, зургийн ажлын даалгаврыг гарган хүргүүлсэн байна.

5. Орон нутгийн зүгээс энэ жил гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг, төсөв хийгдэн, энэ хүрээнд яамны зүгээс гүйцэтгэлийн хөрөнгийг улсын төсөвт тусгахад дэмжлэг үзүүлж анхаар өгөхийг хүссэн саналыг тавьсан.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум нь босоо чиглэлийн орон нутгийн зэрэглэлтэй авто зам дагуу байрласан. Улаанбаатар хотоос 365 км, аймгийн төвөөсөө 82 км зайд байрладаг.

Ажлын хэсэг 2025 оны 03-р сарын 26-ны өдөр ажилласан. Уулзалтад тус сумаас ИНХ-ийн дарга, Засаг дарга н. Г.Цэндсүрэн, "Цагааннуур тохижилт" ААТҮГ-ийн захирал н.Алтансүх нар оролцлоо.



Хүн ам- 5068

Өрхийн тоо- 1308 /сумын төв 955 өрх/

Төрийн албан хаагч- 232

Тус сумын төвд дулааны шугамд 21 аж ахуйн нэгж байгууллага, 42 өрх, нийт 63 объект, цэвэр, бохирын системд 11 аж ахуйн нэгж, байгууллага, 25 айлын нэг орон сууц, хаус 14, гэр хорооллын 20 өрх, нийт 46 объект тус тус холбогдсон.

Нэг цэцэрлэг тусдаа өөрийн уурын зуухаар халаадаг.

Шугам сүлжээнд холбогдсон байгууллага, айл, өрхийн хувьд ашиглалт хэвийн явагдаж байна.

Дулааны ашиглагч байгууллагаар Эл Си Би ХХК ажиллаж байна.

Гэр хорооллын 3 гудамжинд инженерийн шугам сүлжээ орсон, тухайн гудамжны 20 айл өрх цэвэр, бохирын системд холбогдсон.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны захиалгаар 2014-2015 онд Шинэ сум төсөл 5,0 тэрбумын ажил хэрэгжсэн. Тус төсөл арга хэмжээний ажлын хүрээнд дулааны 1600м шугам, цэвэр усны 5986м шугам, 150м³-ийн цэвэрлэх байгууламж, 4165м бохир усны шугам зэрэг ажлууд хийгдсэн.

Цэвэрлэх байгууламжийн ашиглалтыг бүрэн ашиглаж чадахгүй байгаа хүндрэлтэй асуудал байна. Суманд мэргэжлийн хүн байхгүй, аймгаас асууж лавлахаар тодорхой сайн зөвлөмж өгч чадахгүй байна. Ийм учраас цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээний хүрээнд тай бүхнээс мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2026 оны саналд гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг, төсөв хийлгэх саналыг тусгана.

Цэвэр, бохир усны ашиглалтыг “Цагааннуур тохижилт” ААТҮГ-т 2021 оноос хариуцуулан ажиллуулдаг. Одоогоор тусгай зөвшөөрөлгүй ажиллаж байна.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-т 610.0 сая төгрөгөөр экскаватор, 50 ковш, хово зэрэг авто машин авахаар ажиллаж байна.



2014-2015 онд хийгдсэн цэвэрлэх байгууламж /150м³/

Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтаар 2014-2015 онд хэрэгжсэн “Шинэ сум төсөл” арга хэмжээг хийж гүйцэтгэсэн, хугацаандаа ашиглалтад орсон, ашиглалт хэвийн явагдаж байна.
2. Орон нутгаас гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэнтэй холбогдуулан цэвэр ус, цэвэрлэх байгууламж, бохирын инженерийн шугам сүлжээний ашиглалтыг “Цагааннуур тохижилт” ААТҮГ-т хариуцуулан ажиллаж байна.
3. Гэр хорооллын 3 гудамжинд цэвэр, бохир усны шугам байгаагаас 20 айл, өрх холбогдсон бөгөөд цаашид цэвэр усанд 70-100 айл, өрх холбогдох боломжтой байдаг.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2026 оны саналд гэр хорооллын инженерийн шугам сүлжээний зураг, төсөв хийлгэх саналыг тусгахаар ажиллаж байна.
5. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д тухайн сумын мэдээллийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй.

Дархан-Уул аймгийн Хонгор сум

Дархан-Уул аймгийн Хонгор сум нь босоо чиглэлийн улсын зэрэглэлтэй авто зам дагуу байрласан. Улаанбаатар хотоос 220 км, аймгийн төвөөсөө 21 км зайд байрладаг.

Ажлын хэсэг 2025 оны 03-р сарын 26-ны өдөр ажилласан. Уулзалтад тус сумаас ИНХ-ийн дарга, Засаг дарга н. Н.Галбаатар, “Эмтнаран” ОНӨААТҮГ-ийн захирал н.Алтансүх нар оролцлоо.



Хүн ам- 6000

Өрхийн тоо- 1600 /сумын төв 500 өрх, салхит өртөөнд 500 өрх/

Төрийн албан хаагч- 242

Тус сумын төвд дулаан, цэвэр, бохирын шугамд 24 аж ахуйн нэгж байгууллага, 2 давхар, 12 айлын 10 орон сууцны 110 айл, өрх, нийт 34 объект холбогдсон. Харин цэвэр усны шугам сүлжээнд холбогдсон гэр хорооллын 125 айл өрх байдаг бөгөөд тухайн айл, өрхийн усны хэрэглээ улирлын чанартай 5-р сарын 15- 9 сарын 15-ны хооронд холбогддог, тухайн айл өрхүүд 2018 онд тавигдсан магистраль шугамаас өөрсдийн зардлаар холболтыг гүйцэтгэсэн.

Тахилт өртөө төвөөс 13 км зайд байрласан дулаан, цэвэр бохирын шугамд төмөр замын аж ахуйн нэгж байгууллага, 2 давхар найман айлын 16 орон сууц, холбогдсон. Төмөр зам өөрөө хариуцдаг.

Шугам сүлжээнд холбогдсон байгууллага, айл, өрхийн хувьд ашиглалт хэвийн явагдаж байна.

Дулаан, цэвэр, бохир усны ашиглагч байгууллагаар “Эмтнаран” ОНӨААТҮГ ажилладаг 36 албан хаагчтай. Техник тоног төхөөрөмжийн хувьд ковш 2, Хово 1, кантер 1, нийт 4 авто машинтай. Айл өрх, ААНБ-ын соруулдаг бохирыг аймгийн төвөөс дууддаг. Иймд байгууллагын бизнес төлөвлөгөөнд бохирын машин авах талаар тусган орон нутагтаа уламжилсан.

Сумын хэмжээнд 2007, 2018 онд ашиглалтад орсон цэвэр усны 7200м шугам, 2021 онд /Салхит өртөөнд/ 1300м дулааны шугам, 2021 онд 250м³ цэвэрлэх байгууламжийн ажлууд хийгдсэн.

Орон нутагт гэр хорооллын айл өрхийг инженерийн шугамд холбох зураг төсөв байхгүй.

Аймгийн хөрөнгөөр хуучин шугам сүлжээг шинэчлэх ажлын зураг хийгдэж байна. Урьдчилсан байдлаар 4.0 тэрбум төгрөгийн төсөв гарсан.

Орон нутгаас “Эмтнаран” ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагааг дэмжиж арчлалтын зардлыг жилийн төсөвтэй батлан дэмжлэг үзүүлж байна. 2025 онд арчлалтын зардал 400.0 сая төгрөг баталж өгсөн.

Дүгнэлт

1. Улсын хөрөнгө оруулалтаар 2007, 2018 онд цэвэр усны шугам хийгдсэн, ашиглалт хэвийн явагдаж байна.

2. Орон нутгаас гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэнтэй холбогдуулан дулаан, цэвэр ус, цэвэрлэх байгууламж, бохирын

инженерийн шугам сүлжээний ашиглалтыг “Эмтнаран” ОНӨААТҮГ-т хариуцуулан ажиллаж байна.

3. Гэр хорооллын гудамжинд хийгдсэн цэвэр усны шугамаас 125 айл өрхүүд өөрсдийн хөрөнгөөр холбогдсон нь тухайн сумын иргэдийн оролцоо идэвхтэй байгаа нь харагдаж байна.

4. Аймгийн хөрөнгөөр хуучин шугам сүлжээг шинэчлэх ажлын зураг хийгдэж байна.

5. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д тухайн сумын мэдээллийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй.

6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдад хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл ирүүлэх тухай 4, 5 дугаартай дотоод албан бичгийг Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газарт, 2023 оны 01 сарын 20-ны өдрийн 03/198 тоот албан албан бичгийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т тус тус хүргүүлж мэдээллийг авч нэгтгэлээ.

2. Дээрх газруудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэн үзэхэд аймгийн төвүүдээс бусад 309 сумаас инженерийн дэд бүтцэд холбогдсон (1952 оноос хойш) нийт 117 сумын судалгааг гаргалаа /Хавсралт 1/. Үүнээс:

- 1952-2000 оны хооронд холбогдсон – 7 сум
- 2000 оноос хойш хэрэгжсэн- 110 сум

3. 2000-2024 онд хэрэгжсэн 110 сумдын инженерийн дэд бүтцийн арга хэмжээ хэрэгжиж, 2020 оноос хойш “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөр, “Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл”, “Гадна инженерийн шугам сүлжээ”, Сумын төвийн цэвэр усны шугам, “Төвийн болон гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ, тохижилт” зэрэг бусад нэршлээр 43 сумдад хэрэгжиж байна.

4. 2020 оноос хойш хэрэгжиж буй инженерийн дэд бүтцийн төсөл арга хэмжээ аймгийн төвийн суманд 43, бусад суманд 43, 2 дүүрэг, нийт 88 төсөл арга, хэмжээ хэрэгжиж байгаагаас 24 арга хэмжээний ажил дуусаж, 64 арга хэмжээний ажил үргэлжилж байна /Хавсралт 2/.

5. Нэгтгэсэн 117 сумын инженерийн дэд бүтцийн мэдээлэл дутуу, ашиглалтад орсноос хойш ашиглагдаж байгаа болон ашиглагдахгүй байгаа нь тодорхойгүй, инженерийн шугам, сүлжээнд холбогдсон сумдын тоо дутуу байгааг <https://urban.gov.mn/> систем болон бусад мэдээллүүдтэй тулган, дэлгэрэнгүй мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэх, шинэчлэх зайлшгүй шаардлага байна.

6. Удирдамжид заагдсан 4 аймгийн 6 сумуудын Сэлэнгэ аймгийн Баянгол суманд 1968 онд хийгдсэн шугам сүлжээтэй бусад 5 сум 2007, 2014-2015, 2018, 2022-2024 онуудад шинээр инженерийн шугам сүлжээ орсон газрууд байна.

7. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумаас бусад сумын удирдлагын зүгээс сумуудын инженерийн шугам сүлжээний хөрөнгө оруулалтын ажил үр дүнтэй, маш сайн хэрэгжсэн гэж үнэлсэн, мөн тухайн төсөл арга хэмжээний ашиглалт, үйлчилгээг ОНӨААТҮГ болон хувийн байгууллагатай гэрээ байгуулан ашиглалтыг авч явж байгаа, дараа дараагийн шатны ажлуудтайгаа уялдуулан ихэнх сумууд орон нутгаас боломжит хөрөнгийг тусган, айл өрхдөө дэмжлэг үзүүлнэ гэсэн чинь эрмэлзэлтэй ажиллаж байгаа нь хөрөнгө оруулалтын ажил үр дүнтэй байна гэж үзэж байна.

8. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д тухайн сумын мэдээллийн бүртгэл хөтлөлт хийгдээгүй байна.

7. НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

1. Нэгтгэсэн 117 сумын инженерийн дэд бүтцийн мэдээлэл дутуу, ашиглалтад орсноос хойш ашиглагдаж байгаа болон ашиглагдахгүй байгаа нь тодорхойгүй, инженерийн шугам, сүлжээнд холбогдсон сумдын тоо дутуу байгаа тул аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д мэдээллүүдийг яаралтай оруулж, дэлгэрэнгүй мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэх, шинэчлэн гаргахыг үүрэгжүүлж, хяналт тавих;

2. Мөн хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем <https://urban.gov.mn/>-д хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг хөрвүүлэн оруулах хөгжүүлэлтийг хийх боломжийг холбогдох байгууллагуудтай хамтран судалж шийдвэрлэхэд анхаарах;

3. Аймаг, сумуудын нийтийн аж ахуйн шугам сүлжээ хариуцан ажиллаж буй байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх, сургалт явуулах, сургалтад бүрэн хамруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлэх;

4. Сумуудын цэвэрлэх байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, шаардлагатай сумуудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран газар дээр нь ажиллаж, мэргэжил, арга зүйгээр хангах /Төв аймгийн Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум санал тавьсан/;

5. Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд бодлогын хүрээнд хяналт тавих, холбогдох байгууллагуудад нэгдсэн зөвлөмж гарган хүргүүлэх. /“Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон”/;

6. Шинээр инженерийн шугам сүлжээний ажил хэрэгжиж буй орон нутгууд болон ашиглалт хариуцах байгууллагад ашиглалтын өмнөх болон дараах зөвлөн туслах, мэргэжил, арга зүйгээр хангах арга хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороотой хамтран авч хэрэгжүүлэх;

7. “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг батлах тухай” Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолын 3 дахь заалт “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.”-ын хэрэгжилтийг хангах.

8. Дээрх тогтоолын хавсралтын 3.1.1 дэх заалт “Сумын төвийн ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээ нэгдсэн нэг удирдлагатай байх”-ын хэрэгжилтийг хангах.

Танилцсан:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын дарга

Тайлан бичсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын ахлах шинжээч

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын шинжээч

 С.Төмөрхүү

 Х.Ган-Очир

 А.Гэрэлт-Од

 Ц.Ууганбаяр

Сумдын инженерийн хангамжийн судалгаа /1952-2024 он/

2025.03.12

№	Аймгийн нэр	№	Сумын нэр	Он	Тайлбар	Сумын тоо
1	Баян-Өлгий	1	Цэнгэл			1
2	Говь-Алтай	1	Дэлгэр	2014-2016	2014-2016 онд Сумын төвийн шинэчлэл төсөл эхэлсэн. Ажил дуусаагүй, гэрээ цуцлах саналтай.	4
		2	Бигэр	2022-2024	2022-2024 онд төсөл хэрэгжиж байгаа, мэдээлэл дутуу	
		3	Халиун	2022-2024	2022-2024 онд төсөл хэрэгжиж дууссан. ГАА-КД-09/2024	
		4	Алтай	2022-2025	2022-2025 онд Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл хэрэгжиж байна.	
3	Завхан	1	Алдархаан	2022		3
		2	Отгон	2022	2020-2022 онд Сумын төвийн шинэчлэл хэрэгжсэн.	
		3	Тосонцэнгэл	2015-2016	2024-2026 онд Сумын төвийн цэвэр усны шугам сүлжээ төсөл хэрэгжиж байна.	
4	Увс	1	Тэс	2015		3
		2	Тариалан			
		3	Малчин			
5	Ховд	1	Алтай	2013-2018		5
		2	Зэрэг	2012-2016		
